



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 09 сарын 26 өдөр

№ 07

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Хадгаламжийн Даатгалын Үндэсний Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 25-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хадгаламжийн Даатгалын Корпорацийн гүйцэтгэх захирал (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЖАВХЛАН

Үндэсний хорооны 2013 оны
09 дүгээр сарын 26-ний өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт

БАНКИНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийг хэрэгжүүлэх, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон олон нийтээс банкны салбарт итгэх итгэлийг алдахгүй байх зорилгоор хадгаламжийн даатгалын сангийн гишүүн банк, тэдгээрийн хадгаламж эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үүднээс төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламжийг шилжүүлэн авч байгаа банк (цаашид “банк” гэх)-инд Хадгаламжийн даатгалын корпораци (цаашид “ХДК” гэх)-иас санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага

2.1. ХДК нь төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламжийг шилжүүлэн авсан банкинд хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

2.2. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөхөд шаардагдах хөрөнгөөс бага байна.

2.3. Банкны хадгаламжийг хуулийн дагуу нөхөн олгоход ХДК-ийн хуримтлуулсан сангийн хөрөнгө хүрэлцэхгүй бол эсхүл нөхөн төлбөр олгох хэмжээ нь сангийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхээр бол төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах замаар хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

2.4. ХДК-иас санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн банк нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- i. Төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламжийг тухайн банкинд шилжүүлэхээр Монголбанкнаас шийдвэрлэж, тухайн банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зөвлөмжийг ХДК-д хүргүүлсэн байна,
- ii. Мөнгөн хадгаламж татах тусгай зөвшөөрөлтэй байх,
- iii. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь 14%-иас багагүй,
- iv. Сүүлийн 12 сарын хугацаанд Монголбанкнаас явуулж буй бодлого, зохицуулалтыг бүрэн биелүүлсэн байх,
- v. Сүүлийн 12 сарын хугацаанд Монголбанкны шалгуур үзүүлэлтийг ханган ажилласан байх.

2.5. ХДК-иас олгох санхүүгийн дэмжлэгийн үр дүнд, банк нь Монголбанкнаас тавьдаг бүхий л шаардлагыг ханган ажиллах боломжтой болохыг нотолсон Монголбанкны албан бичгийг ирүүлнэ.

2.6. Банк нь ХДК-иас тавих шаардлагыг бүрэн ханган биелүүлсэн байхаас гадна цаашдаа санхүүгийн зуучлал, банкны хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхээ нотолсон амлалт бүхий бичгийг ХДК-д ирүүлнэ.

2.7. Амлалт бүхий албан бичиг нь банкны гүйцэтгэх захирлын гарын үсэг, тамга дарж баталгаажсан байна.

Гурав. Санхүүгийн дэмжлэгийн хэлбэр, хэмжээ

3.1. Монголбанк болон банкнаас ирүүлсэн санал, дүгнэлт, тооцоолол, амлалтын дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай ХДК-ийн Гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, хэлбэрийг тогтооно.

3.2. Санхүүгийн дэмжлэгийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлж болно. Үүнд:

- Хадгаламжийн даатгалын сан
- Монгол Улсын төсөв
- Монголбанкны буцалтгүй тусламж, зээл
- Бусад эх үүсвэр

3.3. Санхүүгийн дэмжлэг нь буцалтгүй, эргэн төлөгдөх, үнэт цаас хэлбэрээр дангаар олгох, дамжуулан олгох, хамтран олгож болно.

3.4. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкнаас шилжүүлж буй актив, пассивын зөрүүгээс илүү байж болно.

3.5. Санхүүгийн дэмжлэг нь тус банк санхүүгийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжийг хангасан байна.

Дөрөв. Бусад

4.1. Банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ, ХДК нь Үндэсний хорооноос гаргасан санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай шийдвэрийг Монголбанкинд хүргүүлнэ.

4.2. Хэрэв өөрөөр шийдвэрлээгүй бол, ХДК нь Засгийн газар, Монголбанк, Олон улсын байгууллагаас олгосон зээл, тусламж, бусад санхүүжилтийг эргүүлэн төлөх үүрэг хүлээхгүй.

4.3. Санхүүгийн дэмжлэгийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкинд олгосон бол уг дэмжлэгийг тухайн банкны төрийн өмчийг хувьчлах хувьчлалын орлогоор эргэн төлүүлэхээр төрийн эрх бүхий байгууллагатай тохиролцож болно.

4.4. Төлбөрийн чадварын хүндрэлд орж татан буугдсан банкны чанаргүй актив хөрөнгө, авлагыг барагдуулах замаар ХДК-ийн гаргасан санхүүжилт, дэмжлэгийг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч болно.